



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# НИЙСЛЭЛИЙН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НТАГ-2024/01/НА-СТА-НТГ

Улаанбаатар хот  
2024 он

	Агуулга	
<b>Тайлан бэлтгэсэн:</b>	ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	4
Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга	БҮЛЭГ 1. НИЙСЛЭЛИЙН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН БҮТЭЦ, ОНЦЛОГ .....	6
Х.Түвшинбаяр	БҮЛЭГ 2. НИЙСЛЭЛИЙН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ .....	11
Аудитын менежер	2.1 Нийслэлийн нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл .....	11
Д.Отгонбаяр	2.2 Хотын шуудын орлогын гүйцэтгэл .....	15
Ахлах аудитор	2.3 Дүүргүүдийн төсвийн орлогын гүйцэтгэл .....	17
Г.Долгорсүрэн	БҮЛЭГ 3. НИЙСЛЭЛИЙН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ .....	18
Н.Бадамхатан	3.1 Нийслэлийн нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл .....	18
Н.Энхмэнд	3.2 Хотын шуудын зарлагын гүйцэтгэл .....	19
Аудитор	3.3 Дүүргүүдийн төсвийн зарлагын гүйцэтгэл.....	20
Э.Ундармаа	3.4 Хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт, гүйцэтгэл .....	21
	3.5 ОНӨААН-үүдийн талаар.....	22
	БҮЛЭГ 4. НИЙСЛЭЛИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ .....	23
	БҮЛЭГ 5. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	24
	БҮЛЭГ 6. ТЕЗ-ИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ .....	24
	БҮЛЭГ 7. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ .....	25
	БҮЛЭГ 8. ДҮГНЭЛТ .....	25
	БҮЛЭГ 9. ЗӨВЛӨМЖ .....	26
	ХАВСРАЛТ .....	29
<b>Хаяг:</b> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 1, Амарын гудамж 2, Соёлын төв өргөө, “Г” корпус, 4 дүгээр давхар	Хавсралт 1. Нийслэлийн орлогын гүйцэтгэлийн нэгдсэн тайлан .....	29
<b>Цахим хуудас:</b> open.audit.mn	Хавсралт 2. Нийслэлийн төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан .....	30
	Хавсралт 3. Нийслэлийн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан .....	32
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 325093, 315558, 327734 дугаарын утсаар харилцана уу.	Хавсралт 4. Нийслэл, дүүргийн төсвөөс зориулалт бус болон үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан зөрчлийн нэгтгэл.....	34
	Хавсралт 5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийн нэгтгэл.....	37
	Хавсралт 6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийн нэгтгэл .....	39
<b>2024 оны 04 дүгээр сар</b>	Хавсралт 7. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн гадаад томилолтын зардалтай холбоотой зөрчлийн нэгтгэл .....	44



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Нийслэлийн 2023 оны нэгдсэн төсвийн  
гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын  
тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтын 2.2, 2023 оны А/75, А/160 дугаартай “Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай” тушаал, Нийслэл дэх Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайланг (НТАГ-2024/01/НА-СТА-НТГ) хавсралтаар баталсугай.

2.Аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг 2024 оны 10 дугаар сарын 01-ний дотор мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Х.Нямбаатар)-д зөвлөсүгэй.

3.Аудитаар өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг 2024 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга (Х.Түвшинбаяр)-т үүрэг болгосугай.

4.Аудитын тайланг Үндэсний аудитын газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид тус тус хүргүүлсүгэй.



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002010397

D:\Desktop\2024\Word\Тушаал\№22-2024.04.19\Тайлан\Баталгаажуулах\Тайлан.docx

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗД	Засаг дарга
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НД	Налайх дүүрэг
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НӨХГ	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
НӨҮГ	Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОСНААУГ	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХК	Хаалттай компани
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЧД	Чингэлтэй дүүрэг

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1<sup>1</sup>, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4<sup>2</sup>-д заасан бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн ТЕЗ-ийн бэлтгэсэн нийслэлийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлээ.

### Аудитын зорилт

Нийслэлийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаажуулалтаар нутгийн өөрөө удирдах байгууллага, бусад мэдээлэл хэрэглэгчийг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдсэн.

### Аудитын хамарсан хүрээ

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.1-54.5.5-т заасны дагуу нийслэлийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд дараах бүрэлдэхүүнээр аудит хийсэн. Үүнд:

- Нийслэлийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, түүний танилцуулга /хотын шуудын болон дүүргийн/
- Татварын зарлагын судалгаа /иргэдэд олгосон ХХОАТ-ын хөнгөлөлт/
- Нийслэл, дүүргүүдийн улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл.

Аудитад нийслэл, дүүргүүдийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, НЗДТГ, НӨХГ, 9 дүүргийн СТСХ-ээс ирүүлсэн судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалыг хамруулсан.

### Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 300, 3000, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудит”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу гүйцэтгэлээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын завар, аргачлал”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан батлуулж, аудитын горим сорилыг хэрэгжүүлэв. Үүнд, нийслэл, дүүргүүдийн ЗДТГ-ын СТСХ-ийн болон холбогдох бусад байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа авах, дансны хуулгатай тулган баталгаажуулах, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.

Аудитын тайланд дүүргийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнг нэгтгэсэн бөгөөд улсын төсөв болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд бие даасан гүйцэтгэлийн аудит хийгдсэн тул уг тайланд оруулаагүй болно. Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргасан.

<sup>1</sup> 6.3.1 “Шалгаагдагч этгээдэд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;”

<sup>2</sup> 8.9.4 “Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захиргагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх”

## Тайлангийн онцлог

Нийслэлийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитыг хослуулан тайлагналаа.

## Аудитын багийн бүрэлдэхүүн

Нийслэлийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудитыг Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, аудитын менежер Д.Отгонбаяр нар удирдаж, ахлах аудитор Г.Долгорсүрэн, Н.Бадамхатан, Н.Энхмэнд, аудитор Э.Ундармаа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэсэн.

## БҮЛЭГ 1. НИЙСЛЭЛИЙН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН БҮТЭЦ, ОНЦЛОГ

### 1.1 Төсвийн зорилт

Нийслэлийн 2023 оны төсвийн төслийг дараах үндсэн чиглэл, бодлогыг баримталж боловсруулсан байна Үүнд:

1. Татварын бүртгэлийг сайжруулах, цахимжуулах, цахим төлбөрийн баримтын системийг үе шаттай хөгжүүлэх замаар далд эдийн засгийг бууруулах, татварын суурийг өргөжүүлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
2. Төсвийн бүх шатны байгууллага, төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, санхүүгийн сахилга батыг мөрдүүлэх;
3. Төрийн албаны цалин хөлсний тогтолцоог бүтээмжтэй нь уялдуулж шинэчлэх;
4. Төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах, өмнөх жилүүдэд эхлүүлсэн төсөл арга хэмжээг хугацаанд нь дуусгах, ашиглалтад оруулах, ирэх онуудад шинээр хэрэгжүүлэх төслүүдийн бэлтгэл ажлыг хангах.

### 1.2 Төсвийн бүтэц

Нийслэлийн нэгдсэн төсөв нь хотын шуудын болон дүүргүүдийн төсвөөс бүрддэг. 2023 оны төсөв нь дараах үндсэн бүтэцтэй байна. Үүнд:

1. Хотын шуудын болон дүүргүүдийн төсөв
2. Дүүргүүдэд олгох санхүүгийн дэмжлэг
3. Дүүргүүдийн төсвөөс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлого
4. Улсын төсөвт шилжүүлэх орлого
5. Нийслэл, дүүргийн ОНХС-д олгох шилжүүлэг
6. Улсын төсөвт төлөх зээлийн эргэн төлөх үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр

### 1.3 Нийслэлийн 2023 оны төсвийн онцлог

1.3.1 Монгол Улсын Их Хурал 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, болон бусад дагалдах хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэн баталсан.

1.3.2 Нийслэлийн нийт орлого 2,001,627.5 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 2,205,040.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөө 203,412.6 сая төгрөгөөр буюу 110.2 хувиар давж биелсэн.

1.3.3 Нийслэлийн нийт зарлага 2,357,713.3 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 1,915,903.3 сая төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 441,810.0 сая төгрөг буюу 18.7 хувийг дутуу зарцуулсан.

1.3.4 Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3<sup>3</sup> дахь заалтын дагуу урьд оны үлдэгдлээс хотын шуудын зарлагын 237,076.3 сая, дүүргүүдийн 130,179.9 сая, нийт 367,256.2 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөгөөнд тусган баталсан.

1.3.5 Өмнөх оны төсвийн гүйцэтгэлтэй харьцуулахад төсвийн орлого 601,440.6 сая төгрөг буюу 37.5 хувиар /2022 онд 1,603,599.5 сая, 2023 онд 2,205,040.1 сая төгрөг/, зарлага 498,554.2 сая төгрөг буюу 35.2 хувиар /2022 онд 1,417,349.1 сая, 2023 онд 1,915,903.3 сая төгрөг/ тус тус нэмэгдсэн.

1.3.6 Сангийн яамнаас нийслэлийн төсвийн суурь орлогыг 1,625,339.7 сая төгрөг, суурь зарлагыг 606,996.1 сая төгрөгөөр хянажээ. Өмнөх онтой харьцуулахад суурь орлогыг 237,981.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, суурь зарлагыг 220,776.1 сая төгрөгөөр бууруулсан байна.

1.3.7 Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд нийслэлийн төсвөөс улсын төсөвт шилжүүлэх орлогын хэмжээг 370,226.4 сая төгрөг, нийслэлд ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлгийг 41,325.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ. Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 271,330.5 сая, ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлгийг 15,307.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

1.3.8 Гадаадын зээл тусламжаар нийслэлд хэрэгжиж байгаа 24 төсөл, хөтөлбөрийн дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу тайлант онд 39,924.3 сая төгрөгийн үндсэн төлбөр, 41,525.6 сая төгрөгийн хүүгийн төлбөр төлөхөөр төсөвт тусгасан байна.

#### 1.4 Нийслэлийн 2023 оны төсвийн төлөвлөлт

Нийслэлийн төсөв нь хотын шуудын болон дүүргүүдийн төсвөөс бүрдэж байна.

Хүснэгт 1. Нийслэлийн төсвийн бүтэц /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2023 оны батлагдсан төсөв			
	Орлого	Хувийн жин /хувиар/	Зардал	Хувийн жин /хувиар/
Хотын шуудын төсөв	529,873.2	26.5	1,648,182.2	69.9
Дүүргүүдийн төсөв	1,471,754.3	73.5	709,531.1	30.1
<b>Нийслэлийн нэгдсэн төсөв</b>	<b>2,001,627.5</b>	<b>100.0</b>	<b>2,357,713.3</b>	<b>100.0</b>

Хүснэгтээс хотын шууд нийслэлийн төсвийн 26.5 хувийг бүрдүүлж 69.9 хувийг зарцуулахаар, дүүргүүд 73.5 хувийг бүрдүүлж 30.1 хувийг зарцуулахаар төлөвлөсөн харагдаж байна.

Хотын шуудын төсвөөс нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний машин цагийн зардлын зөрүү санхүүжилт, сургуулиудын автобусны үйлчилгээний дэмжлэгт 170,394.5 сая, нийтийн тээврийн унааны нөхөн олговорт 40,623.1 сая, сайжруулсан түлшний тээвэрлэлт борлуулалт, хадгалалт, хяналт шалгалтын зардалд 38,167.8 сая, нийгмийн халамжийн сангийн зардалд 3,414.1 сая, дамжуулан зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрт 81,449.9 сая төгрөг зэрэг томоохон зардлуудыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Нийслэлийн 2023 оны төсвийн зарлагыг төрөөс хэрэгжүүлж буй бодлого, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн дагуу урсгал зарлагын өөрчлөлтийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, төсвийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийн үргүй зардлыг багасгах, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлийг баримтлан боловсруулсан байна.

Нийслэлийн төсөвт дүүргүүдийн төсвөөс 887,300.1 сая төгрөг /СБД 291,858.9 сая, ХУД 222,789.1 сая, БЗД 127,049.2 сая, БГД 126,079.8 сая, ЧД 108,268.8 сая, СХД 10,501.4 сая, БНД 752.9

<sup>3</sup> 57.3 “Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна.”

сая төгрөг/ төвлөрүүлэхээр, нийслэлийн төсвөөс дүүрэгт 8,267.4 сая төгрөг /БХД 5,071.9 сая, НД 3,195.5 сая төгрөг/-ийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөсөн. Энэ нь өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад дүүргийн төсвөөс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх дүн 259,402.8 сая төгрөгөөр, нийслэлийн төсвөөс дүүргийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 347.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулсан судалгаа /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Орлого				Зардал			
	2022 оны гүйцэтгэл	2023 оны төсөв	зөрүү /өссөн +, буурсан -/	хувь	2022 оны гүйцэтгэл	2023 оны төсөв	зөрүү /өссөн +, буурсан -/	хувь
Хотын шуудын төсөв	527,166.1	529,873.2	2,707.1	0.5	994,893.0	1,648,182.2	653,289.2	65.7
Дүүргүүдийн төсөв	1,076,433.4	1,471,754.3	375,197.7	34.9	422,456.1	709,531.1	287,075.0	68.0
<b>Нийслэлийн нэгдсэн төсөв</b>	<b>1,603,599.5</b>	<b>2,001,627.5</b>	<b>377,904.8</b>	<b>23.6</b>	<b>1,417,349.1</b>	<b>2,357,713.3</b>	<b>940,364.2</b>	<b>66.3</b>

Хүснэгтээс харахад хотын шуудын орлогыг өмнөх оны гүйцэтгэлээс 0.5 хувиар, зарлагыг 65.7 хувиар, дүүргүүдийн төсвийн орлогыг 34.9 хувиар, зарлагыг 68.0 хувиар тус тус нэмэгдүүлж баталжээ.

Татварыг хялбаршуулах, технологийн дэвшил ашиглан бүртгэлийг сайжруулж орон нутгийн төсөвт төвлөрөх хувь хүний орлогын албан татварын нэр, төрлүүдийг бүрэн хураах, татварын баазыг өргөжүүлэх, татвараас зайлсхийх явдлыг багасгах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн өмнөх оны гүйцэтгэлээс төсвийн орлогыг 377,904.8 сая төгрөг буюу 23.6 хувиар нэмэгдүүлж баталсан байна.

Нийслэлийн төсвийн зарлагыг өмнөх оны гүйцэтгэлээс 940,364.2 сая төгрөг буюу 66.3 хувиар нэмэгдүүлж баталсан. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын албан тушаалын цалингийн сүлжээг шинэчлэн тогтоосон, он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл, санхүүжилттэй уялдуулан санхүүжих дүнг нэмэгдүүлсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

**Хотын шуудын төсвийн төлөвлөлт:**

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2<sup>4</sup> дахь заалтыг үндэслэн НИТХ-ын 2023 оны 85, 96, 115 дугаар тогтоолуудаар нийслэлийн төсөвт 3 удаа өөрчлөлт оруулсан.

Хүснэгт 3. Хотын шуудын 2023 оны төсвийн орлогод оруулсан өөрчлөлт /сая төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Анх баталсан (НИТХ-ын 2022 оны 115 дугаар тогтоол)	Төсвийн нэмэлт өөрчлөлтөөр баталсан (НИТХ-ын 2023 оны 115 дугаар тогтоол)	Зөрүү /2-1/	
				дүн	хувь
1	Хотын шуудын нийт орлого	526,127.7	529,873.1	3,745.4	0.7
2	Төсвийн орлого	509,877.9	506,210.6	(667.3)	(0.1)
2.1	Татварын орлого	334,830.8	340,830.8	6,000.0	1.8
2.2	Татварын бус орлого	175,047.1	168,379.8	(6,667.3)	(3.8)
3	Тусламжийн орлого	16,249.8	20,662.5	4,412.7	27.2

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.12<sup>5</sup> дахь заалтыг зөрчиж өмч хувьчлалын орлогыг татварын бус орлогын дүнд оруулж төсөв баталсан.

<sup>4</sup> 34.2.2 "урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон;"

<sup>5</sup> 23.12 "Энэ хуулийн 23 дугаар зүйлд заасныг үл харгалзан өмч хувьчлалын орлогыг төсвийн орлого хэсэгт бүртгэхгүй төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр талд бүртгэнэ."

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг үндэслэн НИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 85 дугаар тогтоолоор нийслэлийн төсөвт дараах өөрчлөлтүүдийг оруулсан байна. Үүнд:

- газрын дуудлага худалдааны орлогыг гүйцэтгэлтэй нь уялдуулан 6,000.0 сая төгрөгөөр, нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын 2022 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашиг болон ногдол ашгийн түвшинтэй уялдуулан хотын шуудын төсөвт төвлөрөх ногдол ашгийн орлогыг 1,362.5 сая төгрөгөөр, Нийслэлийн Соёлын төв өргөө болон Нийслэлийн Архивын газрын үндсэн үйл ажиллагааны орлого өссөнтэй холбоотойгоор хотын шуудын төсөвт байгууллагын өөрийн орлогыг 214.0 сая төгрөгөөр, дүүргийн төсвөөс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх дүнг 16,043.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж;
- “Нийтийн тээврийг сайжруулах төслийн нэгж”-ийн ашиглалтаас үүссэн зээлийн төлбөр дууссантай холбоотойгоор хотын шуудын төсөвт төвлөрч буй хүүгийн орлогыг 6,043.8 сая төгрөгөөр бууруулсан.

Энэхүү тогтоолоор хөрөнгө оруулалтын зардлыг 211,897.7 сая, урсгал зардлыг 44,701.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нийслэлийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх дүнг 223,219.9 сая, зээл, зээлийн хүүгийн төлбөрийг 11,258.0 сая, дүүргийн төсөвт олгох санхүүжилтийг 132.3 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1<sup>6</sup> дэх заалтыг үндэслэн НИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 96 дугаар тогтоолоор нийслэлийн үнэт цаас гаргаж, арилжаалах замаар 429,066.1 сая төгрөгийн орлого олохоор тооцож, эх үүсвэрийг нэмэгдүүлсэн. Энэхүү үнэт цаасны хөрөнгөөр дараах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

- Нийслэлийн төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 62,800.0 сая төгрөг;
- Нийслэлийн инженерийн дэд бүтцийн хүртээмж, авто зам, замын байгууламжийн сүлжээг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 178,766.1 сая төгрөг;
- Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 177,500.0 сая төгрөг;
- Сэлбэ, Дунд голын дагуу үерийн гамшгаас сэргийлж, далан байгуулах, Улаанбаатар хотын авто замын сүлжээний нэвтрүүлэх чадварыг сайжруулж, түгжрэлийг бууруулах зорилгоор хэрэгжүүлж буй Сэлбэ сэргэлт төслийн эхний ээлжийн бүтээн байгуулалтын зардалд 150,000.0 сая төгрөг;
- Үнэт цаас гаргахтай холбогдуулан андеррайтинг үйлчилгээний зардалд 10,000.0 сая төгрөг тус тус зарцуулахаар төлөвлөсөн.

Ингэснээр ачаалал өндөр, нэн шаардлагатай 14 цэцэрлэг, 7 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 11 монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 4 сургуулийн барилгыг ашиглалтад оруулж, цэцэрлэгийн хүчин чадлыг 4 445 ороор, сургуулийн хүчин чадлыг 4 460 суудлаар нэмэгдүүлж, нийт 8 900 орчим хүүхдийг хамран сургах тойрогт буюу гэрийн ойролцоо сурах нөхцөлийг бүрдүүлж, хүүхдийг сургууль цэцэрлэгт хүргэх авто замын хөдөлгөөнд оролцогчийн тоог бууруулж, авто замын ачаалал багасна гэж тооцсон байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос “Улаанбаатар бонд”-ын анхдагч зах зээлийн арилжааг түр хойшлуулсантай холбогдуулан төсвийн орлого буурч, төсөв алдагдалтай болох нөхцөл байдал үүссэн, үнэт цаас гаргаж, арилжаалах замаар татан төвлөрүүлэх дээрх орлогыг олох боломжгүй болсон. Иймд НИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 115 дугаар тогтоолоор хотын шуудын хөрөнгийн зардлыг 401,438.8 сая төгрөгөөр, урсгал зардлыг 27,627.3 сая төгрөгөөр тус тус бууруулж төсөвт өөрчлөлт оруулсан байна.

<sup>6</sup> 13.1 “Нийслэл хуульд заасан нөхцөл, журмын дагуу үнэт цаас гаргаж болно.”

## Хүснэгт 4. Хотын шуудын 2023 оны төсвийн зарлагад оруулсан зарим томоохон өөрчлөлт /сая төгрөгөөр/

Д/ д	Үзүүлэлт	Анх баталсан (НИТХ-ын 2022 оны 115 дугаар тогтоол)	Төсвийн нэмэлт өөрчлөлтөөр баталсан (НИТХ- ын 2023 оны 115 дугаар тогтоол)	Зөрүү /2-1/	
				дүн	хувь
А	Б	1	2	3	4
1	Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, хороодын хэсгийн ахлагч нарын урамшууллын зардал болон бусад зардалд гарсан өөрчлөлт	537,446.1	542,740.7	5,294.6	101.0
2	Авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж	1,759.4	1,641.2	(118.2)	93.3
3	Улаанбаатар хөгжлийн корпораци ХК-ийн үйл ажиллагааны зардал	800.0	1,800.0	1,000.0	225.0
4	Нийслэлийн нутгийн өөрөө удирдах болон нийтийн захиргааны байгууллагуудын нүүлгэлтийн зардал	300.0	-	(300.0)	-
5	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүгийн зардлын зөрүү	5,000.0	12,400.0	7,400.0	248.0
6	Нийслэлийн авто замын хөрөнгөөр хэрэгжүүлэх авто зам, замын байгууламжийн цэвэрлэгээ, үйлчилгээ, засвар, арчлалт бусад зардал	6,175.0	6,685.0	510.0	108.3
7	Дамжуулан зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр	92,707.9	81,449.8	(11,258.1)	87.9
8	Эмээлт эко аж үйлдвэрийн парк ХК-ийн дүрмийн сан	-	1,000.0	1,000.0	
9	Зам тээврийн удирдлагын ухаалаг системийн хүрээнд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зардал	-	1,500.0	1,500.0	
10	Нийслэлийн үнэт цаас гаргах бэлтгэл ажлын зардал	-	289.0	289.0	
11	Хөрөнгийн зардал	364,340.1	604,364.4	240,024.3	65.9

Сангийн яамтай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хэрэгжиж дууссан 2 төсөл, хөтөлбөрийн ашиглалтын гүйцэтгэлд үндэслэн тооцоог тулган баталгаажуулж, гадаадын зээл тусламжийн бүртгэлийн системд үүссэн зөрүү болох 11,258.1 сая төгрөгөөр үндсэн зээл, хүүгийн төлбөрийг бууруулсан байна.

**Дүүргүүдийн төсвийн төлөвлөлт:**

Дүүргүүдийн 2023 оны төсвийн орлого, зарлагыг дүүргүүдийн ИТХ-ын тогтоолоор 1-2 удаа тодотгож, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,590,273.6 сая төгрөгөөр баталсан нь анх баталсан төсвөөс 188,000.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан. БЗД төсвийн орлогоо нийслэлээс хянасан дүнгээс хэт өндөр дүнгээр нэмэгдүүлэн 261,305.5 сая төгрөгөөр баталж, орлогын төлөвлөгөө 38,172.1 сая төгрөгөөр тасарсан, нийслэлд төвлөрүүлэх дүнг 47,049.2 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн.

**Аудитын илрүүлэлт:**

1. СХД дэх ахуйн үйлчилгээний барилга, Мал эмнэлгийн лаборатори, Монгол шуудангийн 21 дүгээр салбар зэрэг өмнөх онуудын жагсаалтаас үлдсэн барилга, байгууламжийг худалдан борлуулахаар тооцсон өмч хувьчлалын орлогыг төсвийн орлогын дүнд оруулж төсөв баталсан.

2. БЗД-ийн ОНӨААТҮГ-ууд нь 2023 оны жилийн эцэст цэвэр ашигтай ажилласан гэж тайлагнасан боловч 2023 оны дүүргийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь хэмжээг ИТХ-аар тогтоолгож, төсвийн орлогыг нэмэгдүүлж төлөвлөөгүй байна. /БЗД-ийн ТТЗ/

3. БГД-ийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 16 дугаар тогтоолоор дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалт баталж, төсвийг 8,040.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Үүнээс он дамжин хэрэгжих 5,900.4 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээг баталсан нь завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. /БГД-ийн ТТЗ/

4. Нийт хөрөнгө оруулалтын зардлын /газар чөлөөлөлтөөс бусад/ 24.5 хувь буюу 2,049.1 сая төгрөгийг тусдаа төсөвтэй, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх төсвийн ерөнхийлөн захирагчтай улсын төсвийн байгууллагуудын хэрэгцээнд зориулан зарцуулсан. /ЧД-ийн ТТЗ/

5. Наадмын үйл ажиллагаанаас 1,123.9 сая төгрөг төвлөрүүлэх боломжтой боловч орлогын төлөвлөгөөг 700.0 сая төгрөгөөр буюу 423.9 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн. /Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо/

6. Төсвийн төлөвлөлтийг бодит байдалд нийцүүлэн төлөвлөөгүй байна. Тухайлбал: түлш, халаалтын зардлыг 46.6 хувиар илүү төлөвлөснөөс зардал хэмнэгдсэн мэт тайлагнасан. /Монголын хүүхдийн ордон/

7. Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 2,984.8 сая төгрөгөөр тасарсан. /Нийслэлийн Нийтийн тээврийн газар/

## БҮЛЭГ 2. НИЙСЛЭЛИЙН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Нийслэлийн нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл

Нийслэлийн 2023 оны төсвийн орлогыг бүрдүүлэхдээ төсвийн тэнцвэрт харьцааг хадгалах хэмжээнд орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн дайчлах, төсвийн орлогын тогтвортой бааз суурийг өргөжүүлэх, татварын ногдуулалт, төлөлтөд тавих хяналтыг сайжруулах, Нийслэлийн ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх зорилтыг хангах ажлын хүрээнд төсвөөс санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг жигд хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд анхаарчээ.

Хүснэгт 5. Нийслэлийн 2023 оны төсвийн орлогын биелэлт /сая төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү (илүү +, дутуу -)	Гүйцэтгэлийн хувь
	<b>Нийт орлого</b>	<b>2,001,627.5</b>	<b>2,205,040.1</b>	<b>203,412.6</b>	<b>110.2</b>
1	<b>Урсгал орлого</b>	<b>1,960,302.4</b>	<b>2,164,324.5</b>	<b>204,022.1</b>	<b>110.4</b>
1.1	Татварын орлого	1,769,157.0	2,011,655.1	242,498.1	113.7
1.2	Татварын бус орлого	191,145.3	152,669.4	(38,475.9)	79.9
2	<b>Тусламжийн орлого</b>	<b>41,325.1</b>	<b>40,715.7</b>	<b>(609.4)</b>	<b>98.5</b>
2.1	ОНХНС-гаас олгох шилжүүлэг	41,325.1	40,715.7	(609.4)	98.5

2023 онд нийслэлийн төсөвт 2,205,040.1 сая төгрөгийн орлого төвлөрч, төсвийн орлогын төлөвлөгөө 203,412.6 сая төгрөгөөр буюу 10.2 хувиар давж биелсэн байна. Төсвийн орлогын гүйцэтгэлийг бүтцээр нь задлан авч үзвэл 2,164,324.5 сая төгрөг буюу 98.2 хувь нь хууль тогтоомжийн дагуу нийслэлийн төсөвт төвлөрөх татварын болон татварын бус орлогын эх үүсвэрээс, 40,715.7 сая төгрөг буюу 1.8 хувь нь тусламжийн орлого буюу ОНХНС-гийн шилжүүлгийн орлогоос бүрдэж байна. /Хавсралт 1/

Нийслэлийн төсөвт төвлөрч буй төсвийн орлогын төлөвлөгөө 204,022.1 сая төгрөгөөр буюу 10.4 хувиар давж биелснээс татварын орлогын төлөвлөгөө 242,498.1 сая төгрөгөөр буюу 13.7 хувиар давж биелэн, татварын бус орлого 38,475.9 сая төгрөгөөр буюу 20.1 хувиар тасарсан дүнтэй байна.

ОНХНС-гаас нийслэлд хуваарилсан шилжүүлгийн орлого 40,715.7 сая төгрөг төсөвт төвлөрч, 609.4 сая төгрөгөөр буюу 1.5 хувиар шилжүүлгийн орлого дутуу төвлөрсөн байна.

Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад нийт орлого 37.5 хувь буюу 601,440.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал

/сая төгрөгөөр/

Төсвийн орлогын ангилал зүйл	2022 оны гүйцэтгэл		2023 оны гүйцэтгэл		Зөрүү	
	дүн	хувийн жин	дүн	хувийн жин	Дүн (өссөн+, буурсан -)	хувь
<b>Нийт орлого</b>	<b>1,603,599.5</b>	<b>100.0</b>	<b>2,205,040.1</b>	<b>100.0</b>	<b>601,440.6</b>	<b>37.5</b>
<b>Урсгал орлогын дүн</b>	<b>1,577,582.4</b>	<b>98.4</b>	<b>2,164,324.5</b>	<b>98.2</b>	<b>586,742.1</b>	<b>37.2</b>
Татварын орлого	1,449,859.0	90.4	2,011,655.1	91.2	561,796.1	38.7
Татварын бус орлого	127,723.3	8.0	152,669.4	6.9	24,946.1	19.5
<b>Тусламжийн орлого</b>	<b>26,017.2</b>	<b>1.6</b>	<b>40,715.7</b>	<b>1.8</b>	<b>14,698.5</b>	<b>56.5</b>

Хүснэгтээс нийт орлогын бүтэц бүхэлдээ өөрчлөгдсөн нь харагдаж байна. Хэдийгээр нийт орлогод татварын орлогын эзлэх хувь ихэнх хувийг эзэлж байгаа боловч тусламжийн орлогын эзлэх хувь 1.6 хувиас 1.8 хувь болж 14,698.5 сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын дүнд урсгал орлогын эзлэх хувийн жин өмнөх оноос 37.5 хувиар өсөхөд татварын орлого 38.7 хувиар өссөн нь нөлөөлжээ.

### 2.1.1 Татварын орлого

Нийслэлийн төсөвт төвлөрч буй төсвийн орлогын төлөвлөгөө 292,839.4 сая төгрөгөөр давж, 50,432.6 сая төгрөгөөр тасарсан ба нийт татварын орлогын төлөвлөгөө 13.7 хувиар давж биелсэн байна. Хүснэгтээр харуулбал:


Хүснэгт 7. Нийслэлийн 2023 оны төсвийн орлогын биелэлт

/сая төгрөгөөр/

№	Татварын төрөл	Давсан орлого	№	Татварын төрөл	Тасарсан орлого
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	78,160.6	113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	(12,250.1)
110002	Үйл ажиллагааны орлого	7,939.1	110003	Хөрөнгийн орлого	(6,101.7)
110004	Хөрөнгө борлуулсны орлого	12,600.9	113002	Бууны албан татвар	(63.6)
110008	Шууд бус орлого	27,695.4	113004	Малд ногдуулах албан татвар	(65.0)
<b>1100</b>	<b>ААН-ын орлогын албан татвар</b>	<b>140,872.8</b>	118001	Улсын тэмдэгийн хураамж	(27,499.6)
110001	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	3,836.7	118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	(1,372.5)
110002	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	260.5	118101	Газрын төлбөр	(1,953.9)
110004	Дуудлага худалдаа	18,607.1	118201	Ойн нөөц ашигласны төлбөр	(2.8)
110008	Нийслэл хотын албан татвар	2,866.3	118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	(1,123.4)
	<b>Нийт</b>	<b>292,839.4</b>		<b>Нийт</b>	<b>(50,432.6)</b>

График 1. Татварын орлогын биелэлт нэр төрлөөр

/сая төгрөгөөр/



Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу 2023 онд татварын хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагдах иргэдийн тайланг харьяа дүүргийн татварын хэлтсээр дамжуулан хүлээн авч, Нийслэлийн Татварын газраас баталгаажиж ирсэн жагсаалтын дагуу 28 906 татвар төлөгч иргэдэд 39,908.7 сая төгрөгийн буцаан олголтыг хуулийн дагуу бүрэн олгосон.

Сангийн сайдын “Тушаал, журамд өөрчлөлт оруулах тухай” 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 221 дүгээр тушаалын 3 дугаар зүйлийн 38<sup>7</sup> дахь заалтыг үндэслэн нэмэлт өөрчлөлт орсны дагуу 2023 онд улсын төсвөөс аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 140,872.8 сая төгрөгийг нийслэлийн төсөвт нэмж хуваарилсан нь 2023 оны төсвийн орлогын бүрдүүлэлтэд эерэг нөлөөллийг үзүүлсэн байна.

Газрын дуудлага худалдааны анхны үнийг нөхөн бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэн ажилласнаар газрын дуудлага худалдааны орлого 18,607.1 сая төгрөгөөр давж биелсэн. ЧД-ийн нутаг дэвсгэрт байрлаж байсан Байгаль орчны яамны шинэ ажлын байр 2023 оны 1 дүгээр сараас ХУД-т шилжин байршсантай холбоотойгоор ХУД энэ төрлийн татварын орлогыг нийслэлээс хянасан дүнгээс хэт өндөр дүнгээр нэмэгдүүлэн баталсан нь улсын тэмдэгтийн хураамжийн орлого 27,499.6 сая төгрөгөөр тасрахад нөлөөлсөн байна.

Хотын шуудын төсөвт төвлөрч буй авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлого 3,836.7 сая төгрөгөөр, нийслэл хотын албан татвар 2,866.3 сая төгрөгөөр давж биелсэн бол дүүргүүдийн төсөвт төвлөрч буй Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 12,250.1 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь БЗД 2023 оны төсвийн төлөвлөгөөг дүүргийн ИТХ-аараа хэлэлцүүлэн батлуулахдаа нийслэлээс хянасан дүнгээс хэт өндөр дүнгээр нэмэгдүүлэн баталсантай холбоотой байна.

### 2.1.2 Татварын бус орлого

2023 онд нийслэлийн төсөвт татварын бус орлогоор 232,470.4 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 193,385.0 сая төгрөг төвлөрч, 39,085.4 сая төгрөгөөр буюу 16.8 хувиар тасарсан дүнтэй байна.

<sup>7</sup> “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого тухайн жилийн батлагдсан төлөвлөгөөний дүнгээс давсан тохиолдолд аймаг, нийслэлийн төсөвт хуваарилж болно.”

## Хүснэгт 8. Нийслэлийн 2023 оны төсвийн орлогын биелэлт

/сая төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>232,470.4</b>	<b>193,385.0</b>	<b>39,085.4</b>	<b>83.2</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>191,145.3</b>	<b>152,669.4</b>	<b>38,476.0</b>	<b>79.9</b>
120001	Хувьцааны ногдол ашиг	1,862.5	1,078.0	784.5	57.9
120003	Торгуулийн орлого	113,103.9	98,899.7	14,204.2	87.4
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,179.3	14,116.3	4,063.0	77.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,669.1	1,970.3	698.8	73.8
120005	Түрээсийн орлого	1,800.0	1,973.9	(173.9)	109.7
120009	Бусад орлого	53,530.5	34,631.2	18,899.3	64.7
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	41,325.1	40,715.7	609.4	98.5

Тайлант онд татварын бус орлогын тасалдлыг нэр төрлөөр нь задлан авч үзвэл нийслэлийн өмчит газруудаас төсөвт төвлөрүүлж буй ноогдол ашиг 784.5 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 4,761.9 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлого 14,204.2 сая төгрөгөөр, ангилагдаагүй бусад орлого 18,899.3 сая төгрөгөөр тус тус тасарч, түрээсийн төлбөр 173.9 сая төгрөгөөр давж биелсэн байна.

## График 2. Татварын бус орлогын биелэлт нэр төрлөөр

/сая төгрөгөөр/



Нийслэлд нийслэлийн өмчийн нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулаагүйгээс 2023 онд өмч хувьчлалын орлого 2,200.0 сая төгрөгөөр тасарсан. Хадгаламж зээлийн хоршоодод 2014-2016 онуудад олгосон бичил зээлийн эргэн төлөлт хуваарьт хугацаандаа төлөгдөөгүйгээс төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө нийслэлийн дүнгээр 4,761.9 сая төгрөгөөр тасрахад нөлөөлсөн байна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 90 дүгээр тогтоолоор нийслэлийн өмчит үйлдвэрийн 9 газраас 1,862.5 сая төгрөгийн ногдол ашгийг төсөвт төвлөрүүлэхээр баталснаас Зорчигч тээвэр-3, Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ууд нь ногдол ашгийн орлогыг 784.5 сая төгрөгөөр тасалдуулсан.

**2.1.3 Тусламжийн орлого**

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар ОНХНС-аас нийслэлд хуваарилагдаж буй шилжүүлгийг 41,325.1 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 36,780.8 сая төгрөгийн шилжүүлэг олгосон байна.

Хүснэгт 9. ОНХС-ийн судалгаа

/сая төгрөгөөр/

№	Нийслэл, дүүрэг	2022			2023		
		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
1	Хотын шууд	13,087.5	13,056.6	(30.9)	20,662.5	20,366.4	(296.1)
2	Багануур	1,348.7	1,430.4	81.7	2,132.3	2,099.9	(32.4)
3	Багахангай	243.3	257.5	14.1	382.7	376.9	(5.8)
4	Баянгол	1,265.6	1,337.9	72.3	2,016.7	1,986.1	(30.6)
5	Баянзүрх	2,997.9	3,163.9	166	4,850.2	4,776.7	(73.5)
6	Налайх	1,004.1	1,065.2	61.2	1,586.2	1,562.2	(24.0)
7	Сүхбаатар	947.4	1,001.4	54.0	1,484.0	1,461.5	(22.5)
8	Сонгинохайрхан	2,791.0	2,950.4	159.4	4,439.4	437.2	(4,002.2)
9	Хан-Уул	1,152.8	1,211.9	59.1	1,873.4	1,845.0	(28.4)
10	Чингэлтэй	1,209.7	1,283.3	73.6	1,897.7	1,868.9	(28.8)
	<b>Нийт</b>	<b>26,048.1</b>	<b>26,758.5</b>	<b>710.4</b>	<b>41,325.1</b>	<b>36,780.8</b>	<b>(4,544.3)</b>

## 2.2 Хотын шуудын орлогын гүйцэтгэл

Хотын шуудын нийт орлогын төлөвлөгөө 2023 онд 529,873.2 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 683,591.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөө 29.0 хувиар буюу 153,718.3 сая төгрөгөөр давуулжээ. Энэ нь тайлант онд татварын орлого төлөвлөгөөнөөс 59.3 хувь буюу 202,255.4 сая төгрөгөөр давуулж, татварын бус орлого 48,241.0 сая төгрөгөөр тасарсантай холбоотой байна. Хотын шуудын тусламжийн орлогын гүйцэтгэл 98.6 хувьтай байна.

Хүснэгт 10. Хотын шуудын 2023 оны төсвийн орлогын биелэлт

/сая төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
	<b>Нийт орлого</b>	<b>529,873.2</b>	<b>683,591.4</b>	<b>153,718.3</b>	<b>129.0</b>
1.1	Татварын орлого	340,830.8	543,086.2	202,255.4	159.3
1.2	Татварын бус орлого	168,379.8	120,138.8	(48,241.0)	71.3
<b>2</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>20,662.5</b>	<b>20,366.4</b>	<b>(296.1)</b>	<b>98.6</b>

### 2.2.1 Татварын орлого:

Хотын шуудын татварын орлогын төлөвлөгөө 202,255.4 сая төгрөг буюу 59.3 хувиар давж биелсэн байна.

Хүснэгт 11. Хотын шуудын 2023 оны татварын орлогын биелэлт

/сая төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>340,830.8</b>	<b>543,086.2</b>	<b>202,255.4</b>	<b>159.3</b>
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	0.0	17,026.4	17,026.4	
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-40,000.0	-39,908.7	91.3	99.8
110301	ААН-ын орлогын албан татвар	317,100.0	457,972.8	140,872.8	144.4
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0.0	13,166.4	13,166.4	
113003	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	39,406.0	43,242.7	3,836.7	109.7
118001	Улсын тэмдэгтийн хураамж	0.0	2,264.3	2,264.3	
118101	Газрын төлбөр	0.0	4,523.7	4,523.7	
118102	Дуудлага худалдаа	8,000.0	26,607.1	18,607.1	332.6
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	24.8	12.2	-12.6	49.2
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	4,300.0	3,313.1	-986.9	77.0
118302	Нийслэл хотын албан татвар	12,000.0	14,866.3	2,866.3	123.9

Төсвийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу 2022 оны төсвийн жилээс эхлэн өмнө нь хотын шуудын төсөвт төвлөрч байсан Цалин хөлс болон түүнтэй адилтгах ХХОАТ, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, Газрын төлбөрийн орлого 100 хувь дүүргийн төсөвт төвлөрөх болсон. Хуулийн өөрчлөлтийн дагуу эдгээр 3 нэр төрлийн татварын орлогын төлөвлөгөөг дүүргүүдийн төсөвт төвлөрүүлэхээр хянаж баталсан ба 2022 оноос өмнөх оны дутуу төлөлтөөс төсөвт 34,716.5 сая төгрөгийн татварын орлого орсон байна.

### 2.2.2 Татварын бус орлого:

2023 онд нийслэлийн төсөвт татварын бус орлогоор 189,042.4 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 140,505.2 сая төгрөг төвлөрч, 48,537.2 сая төгрөгөөр буюу 25.7 хувиар тасарсан дүнтэй байна.

Хүснэгт 12. Хотын шуудын 2023 оны татварын бус орлогын биелэлт /сая төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>189,042.4</b>	<b>140,505.2</b>	(48,537.20)	<b>74.3</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>168,379.8</b>	<b>120,138.8</b>	(48,241.00)	<b>71.4</b>
120001	Хувьцааны ногдол ашиг	1,862.5	1,078.0	(784.50)	57.9
120003	Торгуулийн орлого	94,375.6	71,311.3	(23,064.30)	75.6
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>18,278.6</b>	<b>13,602.4</b>	(4,676.20)	<b>74.4</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,703.0	11,743.4	(3,959.60)	74.8
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,575.6	1,859.0	(716.60)	72.2
120005	Түрээсийн орлого	1,800.0	1,973.9	173.90	109.7
120009	Бусад орлого	52,063.2	32,173.3	(19,889.90)	61.8
<b>123</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>20,662.5</b>	<b>20,366.4</b>	(296.10)	<b>98.6</b>
123002	ОНХНС-аас шилжүүлсэн орлого	20,662.5	20,366.4	(296.10)	98.6

### 2.2.3 Төсөвт байгууллагын өөрийн орлого

Нийслэлийн төсөвт байгууллагууд өөрийн орлогоо 16 байгууллага 2,489.3 сая төгрөгөөр давуулж, 7 байгууллага 10,285.2 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Нийслэлийн Нийтийн тээврийн газар, Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв, НЗДТГ-ын орлого тасарснаас голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 13. Төсөвт байгууллагын өөрийн төсвийн орлогын биелэлт /сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Давсан орлого	№	Байгууллагын нэр	Тасарсан орлого
1	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар	21.6	1	Нийслэлийн Нийтийн тээврийн газар	(2,984.8)
2	Нийслэлийн Улаанбаатар чуулга	62.5	2	НӨХГ	(168.6)
3	Нийслэлийн Аялал жуулчлалын газар	0.1	3	Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар	(636.9)
4	Нийслэлийн Агаар, орчны бохирдлыг бууруулах газар	1.9	4	Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв	(2,022.5)
5	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн	276.1	5	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны алба	(1.6)
6	Улаанбаатар лифт	47.5	6	Нийслэлийн ЗДТГ	(4,470.7)
7	Монгол наадам цогцолбор	100.2	7	Нийслэлийн Хүүхдийн урлан бүтээх төв	(0.1)
8	Бэлчээрийн менежмент нэгж	3.3		<b>Нийт дүн</b>	<b>(10,285.2)</b>
9	Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газар	38.0			
10	Монголын хүүхдийн ордон	137.8			
11	Нийслэлийн Нийслэлийн Захирагчийн ажлын алба	0.5			
12	Нийслэлийн Архивын газар	25.1			
13	Улаанбаатар хотын төв номын сан	0.4			
14	Улаанбаатар хотын музей	0.3			
15	Нийслэлийн Соёлын төв өргөө	243.9			
16	Нийслэлийн Замын хөгжлийн газар	1,530.1			
	<b>Нийт дүн</b>	<b>2,489.3</b>			

**2.3 Дүүргүүдийн төсвийн орлогын гүйцэтгэл**

Нийслэлийн 9 дүүргийн төсвийн орлого бүрдүүлэлтийг авч үзвэл орлогын төлөвлөгөө 1,471,754.4 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр дүүргүүдийн төсөвт 1,521,448.7 сая төгрөгийн орлого төвлөрч, орлогын төлөвлөгөө 3.4 хувиар буюу 49,694.4 сая төгрөгөөр давсан байна. Энэ нь нийслэлийн төсвийн 69.0 хувийг бүрдүүлсэн байна. Орлогын төлөвлөгөөг 8 дүүрэг 3.5-30.7 хувиар давуулан биелүүлж, БЗД-ийн орлого 14.6 хувиар тасарсан байна.

Хүснэгт 14. Нийслэлийн дүүргүүдийн төсвийн орлогын биелэлт /сая төгрөгөөр/

Дүүрэг	2023 он		Биелэлт	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1. Багануур дүүрэг	17,877.7	18,735.4	857.7	104.8
2. Багахангай дүүрэг	1,649.2	2,155.8	506.7	130.7
3. Баянгол дүүрэг	184,167.5	194,050.0	9,882.5	105.4
4. Баянзүрх дүүрэг	261,305.6	223,133.5	(38,172.1)	85.4
5. Налайх дүүрэг	14,859.2	17,209.4	2,350.2	115.8
6. Сонгинохайрхан дүүрэг	96,850.7	102,924.8	6,074.1	106.3
7. Сүхбаатар дүүрэг	392,424.5	428,240.3	35,815.8	109.1
8. Хан-Уул дүүрэг	326,215.2	352,501.7	26,286.5	108.1
9. Чингэлтэй дүүрэг	176,404.8	182,497.8	6,093.0	103.5
<b>Нийт дүн</b>	<b>1,471,754.4</b>	<b>1,521,448.7</b>	<b>49,694.4</b>	<b>103.4</b>

**Аудитын илрүүлэлт:**

1. Нийслэлийн төсөвт тайлант онд нийт 2,205,040.1 сая төгрөгийн орлого төвлөрч, төсвийн орлогын төлөвлөгөө 203,412.6 сая төгрөгөөр буюу 10.2 хувиар давж биелсэн ба энэ нь өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад урсгал орлого 37.2 хувь буюу 586,742.1 сая төгрөгөөр, нийт орлого 37.5 хувь буюу 601,440.6 сая төгрөгөөр өссөн эерэг үзүүлэлттэй гарчээ.

2. Нийслэлийн 2023 оны татварын орлогын төлөвлөгөө 13.7 хувиар давж биелсэн нь хувь хүний орлогын албан татвар 120,294.3 сая төгрөгөөр, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 140,872.8 сая төгрөгөөр тус тус давсан нь татварын орлогын төлөвлөгөө давахад голлох нөлөөллийг үзүүлжээ.

3. Нийслэлийн Татварын газраас баталгаажиж ирсэн жагсаалтын дагуу 28,906 татвар төлөгч иргэдэд 39,908.7 сая төгрөгийн буцаан олголтыг хуулийн дагуу бүрэн олгосон байна.

4. 2023 онд нийслэлийн төсөвт татварын бус орлогоор 191,145.3 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 152,669.4 сая төгрөг төвлөрч, 38,476.0 сая төгрөгөөр буюу 20.1 хувиар тасарсан дүнтэй байна.

5. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 90 дүгээр тогтоолоор нийслэлийн өмчит үйлдвэрийн 9 газраас 1,862.5 сая төгрөгийн ногдол ашгийг төсөвт төвлөрүүлэхээр баталснаас Зорчигч тээвэр-3, Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ууд нь ногдол ашгийн орлогыг 784.5 сая төгрөгөөр тасалдуулсан.

6. Нийслэлийн төсөвт байгууллагуудын өөрийн орлогыг 16 байгууллага 2,489.3 сая төгрөгөөр давуулж, 7 байгууллага 10,285.2 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Нийслэлийн Нийтийн тээврийн газар, Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв, НЗДТГ-ын орлого тасарснаас голлон шалтгаалсан байна.

7. Нийслэлийн 9 дүүргийн төсвийн орлого бүрдүүлэлтийг авч үзвэл орлогын төлөвлөгөө 1,471,754.4 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр дүүргүүдийн төсөвт 1,521,448.7 сая төгрөгийн орлого төвлөрч, орлогын төлөвлөгөө 3.4 хувиар буюу 49,694.4 сая төгрөгөөр давсан байна. Энэ нь нийслэлийн төсвийн 69.0 хувийг бүрдүүлсэн байна. Орлогын төлөвлөгөөг 8 дүүрэг 3.5-30.7 хувиар давуулан биелүүлж, БЗД-ийн орлого 14.6 хувиар тасарсан байна.

### БҮЛЭГ 3. НИЙСЛЭЛИЙН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

#### 3.1 Нийслэлийн нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл

Нийслэлийн нэгдсэн төсвийн 2023 оны нийт зарлага 2,357,713.3 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,915,903.3 сая төгрөг зарцуулж, 81.3 хувийн гүйцэтгэлтэй, өмнөх оны гүйцэтгэлээс 498,554.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 15. Нийслэлийн 2023 оны төсвийн зарлагын гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2023 он		Зөрүү илүү /+/, дутуу/ -/	Гүйцэтгэлийн хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>2,357,713.3</b>	<b>1,915,903.3</b>	<b>(441,810.0)</b>	<b>81.3</b>
<b>Урсгал зардал</b>	<b>1,488,820.6</b>	<b>1,353,768.0</b>	<b>(135,052.6)</b>	<b>90.9</b>
Бараа ажил үйлчилгээний зардал	751,122.6	667,033.5	(84,089.1)	88.8
Хүү	51,073.9	51,073.9	-	100.0
Татаас	229,073.6	211,114.7	(17,958.9)	92.2
Урсгал шилжүүлэг	457,550.5	424,545.9	(33,004.6)	92.8
<b>Зээлийн төлбөр</b>	<b>39,924.3</b>	<b>39,924.3</b>	<b>-</b>	<b>100.0</b>
<b>Хөрөнгийн зардал</b>	<b>828,968.4</b>	<b>522,211.0</b>	<b>(306,757.4)</b>	<b>63.0</b>

Нийслэлийн хэмжээнд 913 орон тоо дутуу ажилласан, Хангарди ордон ашиглалтад бүрэн ороогүйгээс байр ашиглалтын зардал, тавилга, эд хогшил худалдан авах зардал хэмнэгдсэн, албан тушаалын суудлын автомашины хэрэглээг хязгаарлах, төсвийн байгууллагад дүрэмт хувцас худалдаж авахгүй байх, албан томилолт, зочны зардал болон төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлдэхгүй байх, сургалт семинар, хурал зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулж, бичиг хэрэг болон албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах, төсвийн байгууллагын өдөр тутмын ажиллагаанаас зардал хэмнэх зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, зарим төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлуудыг санхүүжүүлээгүй зэргээс шалтгаалан 441,810.0 сая төгрөг дутуу зарцуулсан байна. /Хавсралт 2/

Урсгал зардлын 157,145.7 сая төгрөг буюу 11.6 хувийг цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлд, 163,987.9 сая төгрөг буюу 12.1 хувийг нийтийн тээврийн нөхөн олговорт олгох татаас шилжүүлэгт, 190,307.6 сая төгрөг буюу 14.1 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт, 472,100.4 сая төгрөг буюу 34.9 хувийг үйл ажиллагааны бусад урсгал зардалд тус тус зарцуулж, 370,226.4 сая төгрөг буюу 27.3 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг эзэлж байна. Хөрөнгийн зардал 522,211.0 сая төгрөг болж өмнөх оноос 56,085.4 сая төгрөгөөр буурсан байна. Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээнд өнгөрсөн онд 420,000.0 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 270,190.2 сая төгрөг зарцуулсан. Тайлант онд дээрх төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэн санхүүжүүлэхэд нийт 205,354.7 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 16. Нийслэлийн 2023 оны төсвийн зарлагын бүтэц /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэл ийн хувь	Нийт зардалд эзлэх хувь	
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Хотын шуудын төсөв	1,648,182.1	1,384,150.8	(264,031.3)	84.0	69.9	72.2
Дүүргийн төсөв	709,531.2	531,752.5	(177,778.7)	74.9	30.1	27.8
<b>Нийт төсөв</b>	<b>2,357,713.3</b>	<b>1,915,903.3</b>	<b>(441,810.0)</b>	<b>81.3</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Өмнөх онд нийт зардлын 69.6 хувийг хотын шууд, 30.4 хувийг дүүргүүд эзэлж байсан бол 2023 онд 72.2 хувийг хот, 27.8 хувийг дүүргүүдийн зарлага эзэлж, дүүргийн зардлын эзлэх хувь 2.6 пунктээр буурсан, нийслэлд төвлөрүүлэх шилжүүлэг 225,723.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.2 Хотын шуудын зарлагын гүйцэтгэл

Хотын шуудын 2023 оны зарлагыг 1,648,182.1 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 1,384,150.8 сая төгрөг зарцуулж, 264,031.3 сая төгрөгөөр дутуу зарцуулжээ. Нийт зардлын 69.0 хувийг урсгал зардал, 28.2 хувийг хөрөнгийн зардал, 2.9 хувийг зээлийн төлбөр тус тус эзэлж, урсгал зардлын 38.8 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг, 17.2 хувийг нийтийн тээврийн нөхөн олговорт олгох татаас шилжүүлэгт, 44.0 хувийг бусад урсгал зардалд тус тус зарцуулсан байна.

Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал хотын шуудын зардал 428,639.6 сая төгрөг буюу 39.6 хувиар өссөн. Бараа үйлчилгээний урсгал зардлын эзлэх хувийн жин 0.7 пунктээр, татаас 1.3 пунктээр, хөрөнгийн зардал 19.0 пунктээр тус тус буурч, хүүгийн төлбөр 2.1 пунктээр, зээлийн эргэн төлөлт 2.9 пунктээр, урсгал шилжүүлэг 15.9 пунктээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хотын шуудын төсвөөс улсын төсөвт 370,226.4 сая төгрөгийн орлогыг шилжүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 370,226.4 сая төгрөгийн орлогыг бүрэн шилжүүлжээ. Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 271,330.5 сая төгрөг буюу 36.4 хувиар өссөн байна.

Хотын шуудын төсвөөс дүүргүүдийн төсөвт 8,267.4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор батлагдаж, санхүүжилтийг бүрэн олгожээ. /БХД 5,071.9 сая, НД 3,195.5 сая төгрөг/. Өмнөх оны гүйцэтгэлээс 347.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Гадаадын зээл тусламжаар нийслэлд хэрэгжиж байгаа 24 төсөл, хөтөлбөрийн дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу тайлант онд 39,924.3 сая төгрөгийн үндсэн төлбөр, 41,525.6 сая төгрөгийн хүүгийн төлбөр төлөхөөр төсвийн төсөлд тусгасныг бүрэн барагдуулсан байна.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2023 оны аудит хийх төлөвлөгөөг үндэслэн Санхүүнийцлийн аудитын хэлстийн аудиторуд БНПУ-ын Варшав, Япон улсын Токио, БНСУ-ын Сөүл, Тайвань улсын Тайбэй, БНХАУ-ын Чунчин хотууд дахь Улаанбаатар хотын Төлөөлөгчийн газрын 2021-2023 онуудын санхүүгийн үйл ажиллагааны зардалд аудит хийсэн. Аудитаар зарим төлөөлөгчийн газарт кассын тайлан гаргадаггүй, анхан шатны баримтад дансны хуулга хавсаргаагүй, хамтын ажиллагаатай байгууллагуудтай үйл ажиллагаа явуулж, хамтран ажиллах гэрээ, хэлцэл, хөтөлбөрүүдийг баталгаажуулах албан ёсны тамга, тэмдэггүй, тухайн улсдаа оршин суух зөвшөөрөлгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай компьютер, принтер, бусад техник хэрэгслээр дутмаг зэрэг нийтлэг зөрчил илэрснийг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх, зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллахыг зөвлөсөн.

### 3.3 Дүүргүүдийн төсвийн зарлагын гүйцэтгэл

Дүүргүүд 2023 онд 709,531.2 сая төгрөгийг зарцуулахаар баталснаас гүйцэтгэлээр 531,752.5 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 177,778.7 сая төгрөг буюу 25.1 хувиар дутуу зарцуулжээ.

Дүүргүүдийн төсвийн зарлагыг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал нийт дүнгээрээ 101,376.6 сая төгрөг буюу 19.1 хувиар өссөн байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

1. Төсвийн хөрөнгийг зориулалт бус, үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан нийт 1,205.2 сая төгрөгийн 44 зөрчил илэрснээс 14.5 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт, 708.5 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 482.2 сая төгрөгийн зөрчилд 34 зөвлөмж өгсөн. /Хавсралт 4/

2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй нийт 2,080.1 сая төгрөгийн 87 зөрчил илэрснээс 24.6 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт, 1,063.5 сая төгрөгийн зөрчилд 25 албан шаардлага, 992.0 сая төгрөгийн зөрчилд 50 зөвлөмж өгсөн. /Хавсралт 5/

3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй нийт 26,802.9 сая төгрөгийн 52 зөрчил илэрснээс 17,461.5 сая төгрөгийн зөрчилд 24 албан шаардлага, 9,341.4 сая төгрөгийн зөрчилд 28 зөвлөмж өгсөн. /Хавсралт 6/

4. Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1<sup>8</sup> дэх заалтыг хэрэгжүүлээгүй, төрийн байгууллагуудын ажил олгогчийн буруугаас ажлаас халагдсан 7 байгууллагын 12 ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу 111.0 сая төгрөгийн нөхөн олговор олгосон, шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнуудаар төлүүлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. /БГД-ийн ИТХ 48.6 сая, БГД-ийн ЗДТГ 14.9 сая, НЗДТГ 16.0 сая, ЧД-ийн ЗДТГ 12.3 сая, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ 7.6 сая, Хан-эко тээвэр ОНӨААН 6.9 сая, Чандмань налайх ОНӨААН 4.7 сая төгрөг/

5. Нийслэл, дүүргийн ИТХ-д суудалтай улс төрийн намуудад нийт 293.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдаж, гүйцэтгэлээр 293.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь Улс төрийн намын тухай хуулийн 19 дүгээр зүйл Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг 19.1<sup>9</sup>, 19.2<sup>10</sup> дахь заалтуудтай нийцэхгүй байна. /НИТХ 90.0 сая, НД 42.0 сая, ЧД 35.0 сая, БХД 34.0 сая, СБД 34.0 сая, ХУД 29.0 сая, СХД 21.0 сая, БНД 8.5 сая төгрөг/

6. НИТХ, НЗДТГ тайлант онд давхардсан тоогоор 264 албан хаагч 13 улсад 434 хоног ажиллаж 1,009.9 сая төгрөгийг гадаад томилолтын зардалд зарцуулсан. Санхүүгийн тайлангийн аудитаар гадаад томилолтын зардалтай холбоотой 1,754.3 сая төгрөгийн 24 зөрчил илэрснээс 61.0 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт, 789.2 сая төгрөгийн 11 зөрчилд албан шаардлага, 904.1 сая төгрөгийн 10 зөрчилд зөвлөмж өгсөн. /Хавсралт 7/

7. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулж байгууллагын цахим хуудсаар өдөр тутам сурталчилсан мэдээллийг сурталчлуулахаар төсөв үрэлгэн зарцуулсан, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг төлбөртэй сайтуудад байршуулан төсөв зарцуулсан зэрэг нийт 157.9 сая төгрөгийн 5

<sup>8</sup> 103.1 “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ.”

<sup>9</sup> 19.1 “Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналыг нийт хүчинтэй саналын тоотой харьцуулах зарчмаар нэг саналыг мянган төгрөгөөр тооцож, сонгуулийн дүн гарсны дараа гурван сарын дотор багтаан Улсын Их Хуралд суудал бүхий намд төр нэг удаа мөнгөн дэмжлэг үзүүлнэ.”

<sup>10</sup> 19.2 “Улсын Их Хуралд суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд арван сая төгрөгөөр тооцож, Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгоно. Энэхүү санхүүжилтийн 50 хувийг Улсын Их Хурлын гишүүдийн сонгуулийн тойрогт явуулах үйл ажиллагаанд зарцуулна.”

зөрчил илэрснээс 59.8 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 98.1 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн. /ЧД-ийн ЗДТГ, БЗД-ийн ЗДТГ 98.1 сая, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ 25.3 сая, Эмээлт эко аж үйлдвэрийн парк ОНӨААТҮГ 32.0 сая, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар 2.5 сая төгрөг/

8. Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлийн хүрээнд худалдан авах үйл ажиллагаанд захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж, гүйцэтгэлийг баталгаажуулан 52,895.3 сая төгрөгийн эрх нээх албан бичгийг илгээсэн. Мөн аймгуудын ЗДТГ-аас нийтийн тээврийн хэрэгслийн цахим картаар үнэ төлбөргүй зорчсон хөдөө, орон нутгийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тайлант оны 85.0 сая төгрөгийн нөхөн олговрын авлагыг барагдуулаагүй, бүртгэл тайланд тусгаж, тайлагнаагүй, өмнөх оны аудитын албан шаардлагыг хэрэгжүүлээгүй. /Нийслэлийн Нийтийн тээврийн газар/

### 3.4 Хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт, гүйцэтгэл

НТАГ-ын Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтэс нь 2023 онд нийслэлд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд дараах аудитуудыг хийж дэлгэрэнгүй тайланг open.audit.mn цахим хуудаст байршуулсан.

- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн /СНАГ-2024/18-ШТА-ГА/
- Нийслэлийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн /НТАГ-2024/28-11-ШТА-ГА/
- Дүүргийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн /НТАГ-2024/18-11-ШТА-ГА/

**3.4.1 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:** 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөл, арга хэмжээнээс 12 ТЕЗ-д хамаарах 886,022.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 170 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр Нийслэлийн ЗД-д эрх шилжүүлснээс 802,771.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 154 төсөл, арга хэмжээг 488,347.9 сая төгрөгөөр санхүүжүүлжээ.

Үүний 381,318.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 363,067.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 7 төсөл, арга хэмжээ нь шинэ, 504,703.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 163 төсөл, арга хэмжээ шилжих ажил байна.

Нийслэлд эрх шилжсэн 170 төсөл, арга хэмжээнээс 81 төсөл, арга хэмжээ буюу 47.6 хувь нь дууссан үүнээс 32 төсөл, арга хэмжээ 2021-2022 онд хэрэгжиж 2023 онд үнийн индекс тооцуулсан, 39 төсөл, арга хэмжээ буюу 23.0 хувь нь хугацаандаа хэрэгжиж, 40 төсөл, арга хэмжээ буюу 23.5 хувь нь хугацаа хэтэрч, 3 төсөл, арга хэмжээ буюу 1.8 хувь нь удааширсан, 7 төсөл, арга хэмжээ буюу 4.1 хувь нь гэрээ цуцлагдсан, хөрөнгө татагдсан болон бусад шалтгаанаар хэрэгжээгүй байна.

**3.4.2 Нийслэлийн хөрөнгө оруулалт:** Нийслэлийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг боловсруулж, НИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлж 115 дугаар тогтоолоор батлуулсан.

Нийслэлийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж, НИТХ-ын ээлжит XVI дугаар хуралдаанаар хэлэлцүүлж 85 дугаар тогтоол, Нийслэлийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж, НИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 96 дугаар тогтоолоор батлуулсан.

Мөн “Нийслэлийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” НИТХ-ын 2023 оны 96 дугаар тогтоолоор Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2023 онд санхүүжих 429,066.1 сая төгрөг батлагдсан бөгөөд нийслэлийн үнэт цаасыг дотоодын зах зээлд үе шаттайгаар арилжаалах бэлтгэл ажил хангагдсан боловч тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон. Үүнтэй

холбогдуулан НИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 115 дугаар тогтоол тус тус 3 удаагийн тодотголыг батлуулсан.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд улс, нийслэл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 887.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 766 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих зорилгоор Нийслэлийн ЗД-ын 239 дүгээр захирамжаар холбогдох байгууллагуудад эрхийг шилжүүлсэн.

НЗДТГ-ын Хөрөнгө оруулалтын тасгийн хувьд 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа 306 төсөл, арга хэмжээний 288.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулж Сангийн яаманд албан бичгээр болон улсын хөрөнгө оруулалтын цахим системээр уламжлан шийдвэрлүүлсэн.

Нийслэлийн төсвийн 636.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийн материалыг хянан баталгаажуулсан байна. 2023 онд батлагдсан төсөл, арга хэмжээнээс санхүүжилт авах боломжгүй болсон 182.9 тэрбум төгрөгийг 2024 онд шилжүүлж, НИТХ-аар батлуулсан. 2023 онд 70.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээсэн байна.

**3.4.3 Дүүргийн хөрөнгө оруулалт:** Дүүргүүдийн ИТХ-аас баталсан тогтоолд дүүргүүдийн хэмжээнд он дамжих болон шинээр хэрэгжих 624 төсөл, арга хэмжээнд 2023 онд нийт 250,459.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж, гүйцэтгэлээр 132,241.1 сая төгрөг олгосон байна.

2023 онд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 461 төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууссан бөгөөд 42,813.6 сая төгрөгийн өртөг бүхий 274 төсөл, арга хэмжээг хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн байна.

### 3.5 ОНӨААН-үүдийн талаар

Нийслэлийн өмчит 26 ААН нь үндсэн үйл ажиллагааны орлого 825,824.6 сая, үндсэн бус үйл ажиллагааны орлого буюу гадаад валютын ханшийн зөрүүний олз 534.9 сая, нийт 826,359.6 сая төгрөгийн орлоготой ажиллаж, өмнөх оноос 163.5 сая төгрөг буюу 24.6 хувиар өссөн байна.

Үндсэн үйл ажиллагааны зардалд 844,753.2 сая, үндсэн бус үйл ажиллагааны зардалд (*гадаад валютын ханшийн зөрүүний гарз 32.1 сая, үндсэн хөрөнгө худалдсаны гарз 924.1 сая, үнэ төлбөргүй шилжүүлсэн үндсэн хөрөнгийн зардал 1,730.4 сая, бонд эргэлтээс гаргасны гарз 0.7 сая төгрөг*) 2,687.3 сая, нийт 847,440.5 сая төгрөгийг зарцуулж, 21,080.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Алдагдал өмнөх оноос 2,319.2 сая төгрөг буюу 12.4 хувиар нэмэгджээ.

Нийслэлийн төсвөөс санхүүжилт авдаггүй, өөрийн үйл ажиллагаагаар орлого бүрдүүлж ажилладаг 26 ААН-ээс 53.8 хувь нь нийт 10,009.5 сая төгрөгийн ашигтай, 38.5 хувь нь 31,090.4 сая төгрөгийн алдагдалтай, Багахангайн Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ нь ашиг, алдагдалгүй, Улаанбаатар сан ХК нь үйл ажиллагаа явуулаагүй байна. /Хавсралт 8/

Нийслэлийн ЗД-ын 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/688 дугаар захирамжаар нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот 15 байгууллагын 2023 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг баталжээ. Уг захирамжийн 3 дугаар хавсралтаар “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 2023 оны зорилт”-ыг батлахдаа нийт 392,107.7 сая төгрөгийн орлоготой, 447,159.2 сая төгрөгийн зардалтай, 55,051.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн байна.

Үртсэн шахмал түлшний үйлдвэр ОНӨААТҮГ, Багахангайн мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ нь үйл ажиллагаа нь зогссон байгаа тул зорилтот түвшний гэрээ байгуулаагүй байна. Мөн Бэлчээрийн менежмент төслийн нэгж, Улаанбаатар такси каб ХХК, Улаанбаатар девелопмент инвестмэнт ХХК зэрэг байгууллагууд байна.

Дээрх гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүд нийт 384,039.7 сая төгрөг (үүнээс үндсэн бус үйл ажиллагааны орлого 528.9 сая)-ийн орлого, 486,796.9 сая төгрөг (үүнээс үндсэн бус үйл ажиллагааны зардал 858.4 сая)-ийн үйл ажиллагааны зардалтай ажиллаж, орлогын төлөвлөгөө нийт 8,068.0 сая төгрөг буюу 2.1 хувиар тасарч, зардлын төлөвлөгөөг 40,074.8 сая төгрөг буюу 8.9 хувиар хэтрүүлэн зарцуулжээ.

#### **Аудитын илрүүлэлт:**

1. Нэр бүхий арилжааны 3 банкт нийт 7,800.0 сая төгрөгийг гэрээ байгуулан хадгалуулсан боловч их хэмжээний хэлцэл хийхдээ Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрөл аваагүй, Монгол банкны ерөнхийлөгчийн 2019 оны А/13 дугаар тушаалаар баталсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох түүнд хяналт тавих журам”-ын дагуу гэрээ байгуулж байгаа банкны тогтвортой харьцааны шалгуур үзүүлэлт хангаагүй нэр бүхий банканд 2,000.0 сая төгрөгийн хадгаламжийг байршуулсан нь эрсдэлтэй байна. /Нийслэл Өмчит Улаанбаатар Хөрөнгө Оруулалтын менежмент ҮЦК ХХК 7,800.0 сая төгрөг/

2. Сүхбаатар дүүргийн Багахандайт амралт нь газрын гэрээ, гэрчилгээгүй, газрын асуудалтай, мөн сувиллын зориулалтаар баригдсан барилгын ажил зогссон, гүйцэтгэх захирал нь Дүүргийн засаг даргатай үр ашиг, зорилтот түвшний гэрээ байгуулаагүй, цаашид ажиллах эсэх нь эргэлзээтэй. /Сүхбаатар дүүргийн ТТЗ/

3. Зөвхөн материалын зардлаар тооцоолол хийхэд Улаанбаатар чуулга дахь зоогийн газраас 58.6 сая төгрөг /орлого 129.0 сая, зардал 187.6 сая/, НЗДТГ дахь зоогийн газар 203.6 сая төгрөг /орлого 115.9 сая, зардал 319.5 сая/-ийн алдагдал хүлээж байна. Үүнээс хоол үйлдвэрлэлийн өртгийг шинэчлэн тогтоож, зах зээлийн үнэ ханшид нийцүүлэх шаардлага үүсч байна. /Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар/

4. Үйл ажиллагаа явуулаагүй олон жил болсон Улаанбаатар санд бүртгэлтэй 735.6 сая төгрөгийн хөрөнгө эзэнгүйдэх, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт алдагдах эрсдэлтэй байна.

5. Үйл ажиллагаа, чиг үүрэг давхацсан Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж НӨҮГ, Улаанбаатар Шинэ бүтээн байгуулалт ХХК болон Улаанбаатар спорт менежмент ХК, Улаанбаатар Зүүн Азийн залуучуудын наадам зохион байгуулах хороо ХК-ууд байна. Эдгээр байгууллагуудыг нэгтгэх, чиг үүргийн давхардлыг арилгах, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулахад анхаарч ажиллаагүй байна.

6. Багахангайн мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-ыг Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 2013 оны 5 дугаар сарын 13-ны өдөр бүхэлд нь битүүмжилсэн, үйл ажиллагааг зогсоосон боловч, жил бүр /тухайлбал, 2021 онд 63.0 сая, 2022 онд 64.8 сая, 2023 онд 56.4 сая төгрөг/ орон нутгийн төсвөөс санхүүжилт олгож төсвийг үрэлгэн зарцуулж байна.

#### **БҮЛЭГ 4. НИЙСЛЭЛИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ**

Нийслэлийн 2023 оны төсвийн урсгал тэнцэл 471,481.7 сая төгрөгийн ашигтай, төсвийн нийт тэнцлийг 356,085.9 сая төгрөгийн алдагдалтай төлөвлөж, алдагдлыг урьд оны үлдэгдэл болон орлого давалт, зардлын хэмнэлтээс санхүүжүүлэхээр баталжээ. Төсвийн гүйцэтгэлээр урсгал тэнцэл 810,556.4 сая, нийт тэнцэл 289,136.8 сая төгрөгийн ашигтай гарчээ.

Хүснэгт 17. Нийслэлийн нэгдсэн төсвийн тэнцэл

/сая төгрөгөөр/

Орлого, зарлагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>2,001,627.4</b>	<b>2,205,040.1</b>
<b>Урсгал орлого</b>	<b>1,960,302.3</b>	<b>2,164,324.4</b>
Татварын орлого	1,769,157.0	2,011,655.1
Татварын бус орлого	191,145.3	152,669.3
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>41,325.1</b>	<b>40,715.7</b>
ОНХНС-аас олгох шилжүүлэг	41,325.1	40,715.7
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>2,357,713.3</b>	<b>1,915,903.3</b>
Урсгал зарлага	1,488,820.6	1,353,768.0
Хөрөнгийн зардал	828,968.4	522,211.0
Зээлийн эргэн төлөлт	39,924.3	39,924.3
<b>УРСГАЛ ТЭНЦЭЛ</b>	<b>471,481.7</b>	<b>810,556.4</b>
<b>НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>(356,085.9)</b>	<b>289,136.8</b>
<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР</b>	<b>356,085.9</b>	
Урьд оны үлдэгдэл болон орлого давалт, зардлын хэмнэлт	356,085.9	

**БҮЛЭГ 5. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

Тайлант онд нэмэлт төсвөөр 120,367.9 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн нь өмнөх оноос 33,814.0 сая төгрөг буюу 39.1 хувиар өссөн байна. Нэмэлт төсвийг санхүүжүүлэх эх үүсвэр дараах орлогоос бүрджээ.

Үүнд:

- Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 102,103.7 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 8,276.3 сая төгрөг
- Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 6,501.1 сая төгрөг
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 3,486.8 сая төгрөг

Нэмэлт төсвөөс бараа ажил үйлчилгээний зардалд 79,803.6 сая төгрөг зарцуулсан байна. (цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 505.5 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 64.1 сая, байр ашиглалттай холбоотой зардалд 1.1 сая, хангамж бараа материалын зардалд 438.9 сая, нормативд зардалд 29.2 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 640.7 сая, томилолт, зочны зардал 134.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 48,331.9 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 29,658.0 сая төгрөг)

Нийслэлийн Орон сууцны корпорац ХК-ийн ажилчдад зориулсан орон сууцны хөтөлбөрийн санхүүжилтийн зээлийн эргэн төлөлт 12,400.0 сая, аймгийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчсон нөхөн олговорт 16.5 сая, нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн зээлийн төлбөрт 7,671.6 сая, Нийслэлийн Орон сууцны корпорац ХК хувийн хэвшлийн байгууллагуудын ажилчдад зориулсан орон сууцны хөтөлбөрийн санхүүжилтийн зээлийн хүүгийн төлбөрт 1,876.7 сая, цагаатгалын нөхөн төлбөр болон нэг удаагийн тэтгэмжийн зардалд 5,608.1 сая, биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалд 371.1 сая, Улаанбаатар спорт менежмент ХК, Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК, Эмээлт эко аж үйлдвэрийн парк ХК-ийн дүрмийн санд 7,895.7 сая төгрөг тус тус зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 4,724.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

**БҮЛЭГ 6. ТЕЗ-ИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хүрээнд нийслэл, дүүргийн ИТХ-аас

төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх 57 хөтөлбөр, 89 арга хэмжээнд нийт 2,357,713.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр дээрх хөтөлбөр, арга хэмжээнд 1,915,903.3 сая төгрөг зарцуулсан байна. Тухайлбал, орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт 245,814.2 сая, орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 52,569.7 сая, авто зам 29,915.1 сая, хот байгуулалт, тохижилт 23,257.6 сая, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг 22,623.4 сая, авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээвэр 9,659.7 сая, сургуулийн өмнөх боловсрол 8,792.1 сая, агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр 6,615.8 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна. Энэ нь Хангарди ордон ашиглалтад бүрэн ороогүй, нийтлэг үйлчилгээний 2 төв шинээр нээхээр төлөвлөсөн боловч тодорхойгүй хугацаагаар хойшилсон, гадаргын ус хуримтлуулах төв байгуулах зэрэг зарим хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй хойшилсон, БЗД нийслэлд төвлөрүүлэх дүнг дутуу төвлөрүүлсэн зэргээс шалтгаалан дутуу зарцуулсан байна.

## **БҮЛЭГ 7. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Нийслэлийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар Нийслэлийн ЗД-д Нийслэл, дүүргийн татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлэх, татварын бус орлогын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн зээлийн хүүгийн төлбөрийг нийслэлийн төсөвт төлөвлөх, төлбөрийг барагдуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, “Нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчдад орон сууц худалдах гэрээ”-ний дагуу төсвөөс олгосон төлбөрийн үлдэгдлийг барагдуулах, Нийслэлийн төрийн байгууллагуудын ажил олгогчийн буруугаас ажлаас халагдсан ажилтны нөхөн олговрыг гэм буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй, цалинг төсвийн хөрөнгөөр төлсөн зөрчлийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх зэрэг 4 зөвлөмж хүргүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг НЗДТГ-ын 2023 оны 05-01/6160 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил 400.1 сая төгрөгөөр, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил 314.3 сая төгрөгөөр нэмэгдэж, нийслэлийн төрийн байгууллагуудын ажил олгогчийн буруугаас ажлаас халагдсан ажилтны нөхөн олговрыг гэм буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй, цалинг төсвийн хөрөнгөөр төлсөн зөрчил 197.7 сая төгрөгөөр буурсан боловч өмнөх онд төсвөөс олгосон нөхөн олговрыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж төсөвт төвлөрүүлээгүй байна.

Гадаадын зээл тусламжаар нийслэлд хэрэгжиж байгаа 24 төсөл, хөтөлбөрийн дамжуулан зээлдүүлэх зээл, хүүгийн төлбөрийг нийслэлийн төсөвт төлөвлөж, төлбөрийг барагдуулах зөвлөмжийг хэрэгжүүлж “Нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчдад орон сууц худалдах гэрээ”-ний дагуу төсвөөс олгосон төлбөрийн үлдэгдлийг барагдуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

## **БҮЛЭГ 8. ДҮГНЭЛТ**

Нийслэлийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитад үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Нийслэлийн нийт орлогыг 2,001,627.5 сая, нийт зардлыг 2,357,713.3 сая төгрөгөөр, нийслэлийн төсвөөс улсын төсөвт шилжүүлэх орлогын хэмжээг 370,226.4 сая төгрөг, нийслэлд ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлгийг 41,325.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тус тус баталжээ.
- Нийслэлийн 2023 оны нийт орлого 203,412.7 сая төгрөг буюу 10.2 хувиар давж биелсэн, нийслэлийн 8 дүүрэг төсвийн орлогын төлөвлөгөөг 506.7-35,815.8 сая төгрөг буюу 3.5-30.7 хувиар давуулан биелүүлж, БЗД-ийн орлого 38,172.1 сая төгрөг буюу 14.6 хувиар тасарсан байна.

- Нийслэлийн нэгдсэн төсвийн 2023 оны нийт зарлага 2,357,713.3 сая төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр 81.3 хувь буюу 1,915,903.3 сая төгрөг зарцуулж, 441,810.0 сая төгрөг буюу 18.7 хувиар төсвийг дутуу зарцуулж хэмнэлт өмнөх оны гүйцэтгэлээс 498,554.2 сая төгрөгөөр өссөн байна.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй нийт 26,802.9 сая төгрөгийн 52 зөрчил илэрлээ.
- Нийслэлийн ЗД-ын 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/688 дугаар захирамжаар нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот 28 ААН-ээс 15 ААН-ийн 2023 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг баталсан бөгөөд үйл ажиллагаа явуулаагүй 4 аж ахуйн нэгж байна.
- Нийслэлийн 2023 оны төсвийн урсгал тэнцэл 471,481.7 сая төгрөгийн ашигтай, төсвийн нийт тэнцлийг 356,085.9 сая төгрөгийн алдагдалтай төлөвлөж, алдагдлыг урьд оны үлдэгдэл болон орлого давалт, зардлын хэмнэлтээс санхүүжүүлэхээр баталжээ. Төсвийн гүйцэтгэлээр урсгал тэнцэл 810,556.4 сая, нийт тэнцэл 289,136.8 сая төгрөгийн ашигтай гарчээ.
- Тайлант онд нэмэлт төсвөөр 120,367.9 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн нь өмнөх оноос 33,814.0 сая төгрөг буюу 39.1 хувиар өссөн байна.
- Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хүрээнд нийслэл, дүүргийн ИТХ-аас төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх 57 хөтөлбөр, 89 арга хэмжээнд нийт 2,357,713.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж дээрх хөтөлбөр, арга хэмжээнд 1,915,903.3 сая төгрөг зарцуулсан байна
- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил 400.1 сая төгрөгөөр, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил 314.3 сая төгрөгөөр нэмэгдэж, нийслэлийн төрийн байгууллагуудын ажил олгогчийн буруугаас ажлаас халагдсан ажилтны нөхөн олговрыг гэм буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй, цалинг төсвийн хөрөнгөөр төлсөн зөрчил 197.7 сая төгрөгөөр буурсан боловч өмнөх онд төсвөөс олгосон нөхөн олговрыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж төсөвт төвлөрүүлээгүй байна.

## БҮЛЭГ 9. ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

### Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Ж.Батбаясгаланд

- Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.12 дахь заалтын дагуу өмч хувьчлалын орлогыг төсвийн орлогын хэсэгт бүртгэлгүй төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр болгон төлөвлөж байх;
- Үйл ажиллагаа нь зогссон Улаанбаатар сангийн хөрөнгийг ажлын хэсэг байгуулж бүртгэх, хэрэгцээтэй газарт нь шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажиллах мөн Бэлчээрийн менежмент төслийн нэгж, Улаанбаатар такси каб ХХК, Улаанбаатар девелопмент инвестмэнт ХХК, Багахангай мах боловсруулах үйлдвэр, Үртсэн шахмал түлшний үйлдвэр ОНӨААТҮГ зэрэг байгууллагуудын үйл ажиллагаанд мониторинг хийж, үйл ажиллагааг жигдрүүлэх, татан буулгах ажлыг зохион байгуулах, цаашид ОНӨААН байгуулахад үйл ажиллагаа, чиг үүргийн давхардлын судалгааг үндэслэх

### Нийслэлийн Дотоод аудитын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Гүрбазарт

- Эрх бүхий албан тушаалтны хууль бус шийдвэрээр ажлаас халагдсан албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалин бусад олговрыг төсвөөс төлсөн зөрчил жил бүр давтагдан гарч байгаа тул нийслэл, дүүргийн дотоод аудитын нэгж гэм буруутай албан тушаалтнаар төлүүлэх арга хэмжээ авч ажиллах, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2-т заасан үүргийг хэрэгжүүлэх;

**Нийслэлийн ЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Б.Энхжин нарт:**

- Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн тогтвортой байдлыг хангасан, төсвийг иж бүрэн, үнэн зөв төлөвлөж, батлан, хэрэгжүүлж, тайлагнахад тухай бүр хяналт тавьж санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;
- Нийслэл, дүүргийн татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлэх, татварын бус орлогын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах;
- Төсөвтэй холбоотой хууль тогтоомж, журам зааврыг мөрдөх, төсвийн сахилга, хариуцлагыг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг үрэлгэн, зориулалт бусаар зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах;
- “Нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчдад орон сууц худалдах гэрээ”-ний дагуу төсвөөс олгосон төлбөрийн үлдэгдлийг барагдуулах;
- Үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хангаагүй арилжааны банкинд байршуулсан хөрөнгийг эргүүлэн татаж, нийслэлийн орон нутгийн төсвийн ерөнхий дансанд байршуулах;

**ТЕЗ-ийн ирүүлсэн хариу:**



**МОНГОЛ УЛС  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА**

Жанжин Д. Сүхбаатарын талбай 7,  
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160 0035  
Утас:(976-11) 32 39 77, 32 71 99  
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2024.04.19 № 01/296  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**НИЙСЛЭЛИЙН ДЭХ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ**

Нийслэл дэх төрийн аудитын газраас нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын асуудлын бүртгэлтэй танилцлаа.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлүүдийг арилгах, давтан гаргахгүй байх талаар тодорхой арга хэмжээ авч, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч, үр дүнг тухай бүр хүргүүлж, хамтран ажиллах болно.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ *X.Нямбаатар* Х.НЯМБААТАР



1110200567

## ХАВСРАЛТ

## Хавсралт 1. Нийслэлийн орлогын гүйцэтгэлийн нэгдсэн тайлан

(сая төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>2,001,627.5</b>	<b>2,205,040.1</b>	<b>203,412.6</b>	<b>110.2</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>1,769,157.0</b>	<b>2,011,655.1</b>	<b>242,498.1</b>	<b>113.7</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>1,413,296.3</b>	<b>1,674,554.7</b>	<b>261,258.4</b>	<b>118.5</b>
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>1,136,196.3</b>	<b>1,256,490.6</b>	<b>120,294.3</b>	<b>110.6</b>
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	850,287.2	928,447.8	78,160.6	109.2
110002	Үйл ажиллагааны орлого	36,990.7	44,929.8	7,939.1	121.5
110003	Хөрөнгийн орлого	101,330.6	95,228.9	(6,101.7)	94.0
110004	Хөрөнгө борлуулсны орлого	56,121.4	68,722.3	12,600.9	122.5
110008	Шууд бус орлого	91,466.5	119,161.9	27,695.4	130.3
<b>1101</b>	<b>Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт</b>	<b>(40,000.0)</b>	<b>(39,908.7)</b>	<b>91.3</b>	<b>99.8</b>
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(40,000.0)	(39,908.7)	91.3	99.8
<b>1103</b>	<b>ААН-ын орлогын албан татвар</b>	<b>317,100.0</b>	<b>457,972.8</b>	<b>140,872.8</b>	<b>144.4</b>
110301	ААН-ын орлогын албан татвар	317,100.0	457,972.8	140,872.8	144.4
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>144,602.8</b>	<b>136,060.6</b>	<b>(8,542.2)</b>	<b>94.1</b>
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	104,453.8	92,203.7	(12,250.1)	88.3
113002	Бууны албан татвар	473.2	409.6	(63.6)	86.6
113003	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	39,406.0	43,242.7	3,836.7	109.7
113004	Малд ногдуулах албан татвар	269.7	204.7	(65.0)	75.9
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>211,258.0</b>	<b>201,039.7</b>	<b>(10,218.3)</b>	<b>95.2</b>
<b>1180</b>	<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	<b>106,509.4</b>	<b>77,897.8</b>	<b>(28,611.6)</b>	<b>73.1</b>
118001	Улсын тэмдэгтийн хураамж	87,515.8	60,016.2	(27,499.6)	68.6
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	371.0	631.5	260.5	170.2
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	18,622.6	17,250.1	(1,372.5)	92.6
<b>1181</b>	<b>Газрын төлбөр</b>	<b>88,202.0</b>	<b>104,855.1</b>	<b>16,653.1</b>	<b>118.9</b>
118101	Газрын төлбөр	80,202.0	78,248.1	(1,953.9)	97.6
118102	Дуудлага худалдаа	8,000.0	26,607.1	18,607.1	332.6
<b>1182</b>	<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>4,546.6</b>	<b>3,420.5</b>	<b>(1,126.1)</b>	<b>75.2</b>
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	24.8	22.0	(2.8)	88.7
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	4,521.8	3,398.4	(1,123.4)	75.2
<b>1183</b>	<b>Бусад татвар</b>	<b>12,000.0</b>	<b>14,866.3</b>	<b>2,866.3</b>	<b>123.9</b>
118302	Нийслэл хотын албан татвар	12,000.0	14,866.3	2,866.3	123.9
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>232,470.4</b>	<b>193,385.0</b>	<b>(39,085.4)</b>	<b>83.2</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>191,145.3</b>	<b>152,669.4</b>	<b>(38,475.9)</b>	<b>79.9</b>
120001	Хувьцааны ногдол ашиг	1,862.5	1,078.0	(784.5)	57.9
120003	Торгуулийн орлого	113,103.9	98,899.7	(14,204.2)	87.4
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,848.4	16,086.6	(4,761.8)	77.2
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,179.3	14,116.3	(4,063.0)	77.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,669.1	1,970.3	(698.8)	73.8
120005	Түрээсийн орлого	1,800.0	1,973.9	173.9	109.7
120009	Бусад орлого	53,530.5	34,631.2	(18,899.3)	64.7
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>41,325.1</b>	<b>40,715.7</b>	<b>(609.4)</b>	<b>98.5</b>
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	41,325.1	40,715.7	(609.4)	98.5
<b>14</b>	<b>ТӨСВИЙН ОРЛОГО</b>	<b>1,940,552.1</b>	<b>2,093,728.9</b>	<b>153,176.8</b>	<b>107.9</b>

## Хавсралт 2. Нийслэлийн төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан

(сая төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,357,713.3</b>	<b>1,915,903.3</b>	<b>441,810.0</b>	<b>81.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,488,820.6</b>	<b>1,353,768.0</b>	<b>135,052.6</b>	<b>90.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>751,122.6</b>	<b>667,033.5</b>	<b>84,089.1</b>	<b>88.8</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>151,724.6</b>	<b>139,693.3</b>	<b>12,031.3</b>	<b>92.1</b>
210101	Үндсэн цалин	73,015.3	68,758.8	4,256.5	94.2
210102	Нэмэгдэл	26,666.9	22,146.5	4,520.4	83.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,518.0	14,492.9	2,025.1	87.7
210104	Урамшуулал	11,613.6	11,704.5	(90.9)	100.8
210105	Гэрээт ажлын хөлс	23,910.9	22,590.7	1,320.2	94.5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>19,555.6</b>	<b>17,452.4</b>	<b>2,103.2</b>	<b>89.2</b>
210201	Тэтгэврийн даатгал	13,282.3	12,094.6	1,187.7	91.1
210202	Тэтгэмжийн даатгал	1,605.0	1,381.6	223.4	86.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,256.9	1,080.7	176.2	86.0
210204	Ажилгүйдлийн даатгал	379.0	265.1	113.9	69.9
210205	Эрүүл мэндийн даатгал	3,032.3	2,630.4	401.9	86.7
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>87,332.9</b>	<b>68,777.9</b>	<b>18,555.0</b>	<b>78.8</b>
210301	Гэрэл, цахилгаан	34,504.3	26,123.2	8,381.1	75.7
210302	Түлш, халаалт	31,057.4	26,122.2	4,935.2	84.1
210303	Цэвэр, бохир ус	15,178.9	10,553.2	4,625.7	69.5
210304	Байрны түрээс	6,592.2	5,979.3	612.9	90.7
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>124,367.4</b>	<b>116,888.2</b>	<b>7,479.2</b>	<b>94.0</b>
210401	Бичиг хэрэг	1,740.1	1,606.5	133.6	92.3
210402	Тээвэр, шатахуун	24,854.0	20,587.9	4,266.1	82.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,796.0	2,159.0	637.0	77.2
210404	Ном, хэвлэл	547.7	408.6	139.1	74.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,753.4	88,826.6	1,926.8	97.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,676.3	3,299.7	376.6	89.8
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,340.8</b>	<b>2,879.4</b>	<b>461.4</b>	<b>86.2</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	154.1	142.5	11.6	92.5
210502	Хоол, хүнс	2,808.1	2,407.4	400.7	85.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	378.6	329.5	49.1	87.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>43,055.4</b>	<b>39,344.7</b>	<b>3,710.7</b>	<b>91.4</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,286.9	3,499.5	787.4	81.6
210602	Тавилга	992.4	751.3	241.1	75.7
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	139.3	103.3	36.0	74.2
210604	Урсгал засвар	37,636.8	34,990.6	2,646.2	93.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,469.1</b>	<b>5,576.1</b>	<b>893.0</b>	<b>86.2</b>
210701	Гадаад албан томилолт	4,552.6	4,018.6	534.0	88.3
210702	Дотоод албан томилолт	321.4	160.2	161.2	49.8
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,595.1	1,397.3	197.8	87.6
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>218,018.3</b>	<b>190,307.6</b>	<b>27,710.7</b>	<b>87.3</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	214,426.5	187,396.4	27,030.1	87.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	267.3	230.7	36.6	86.3
210803	Даатгалын үйлчилгээ	205.1	152.5	52.6	74.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	45.2	21.6	23.6	47.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	26.8	5.5	21.3	20.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,477.6	1,218.1	259.5	82.4
210807	Газрын төлбөр	1,288.8	1,035.9	252.9	80.4
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	152.9	149.1	3.8	97.5

НИЙСЛЭЛИЙН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	128.1	97.8	30.3	76.3
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>97,258.5</b>	<b>86,114.0</b>	<b>11,144.5</b>	<b>88.5</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	94,759.4	83,879.2	10,880.2	88.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,499.0	2,234.8	264.2	89.4
<b>211</b>	<b>ХҮҮ</b>	<b>51,073.9</b>	<b>51,073.9</b>	-	<b>100.0</b>
<b>2111</b>	<b>Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр</b>	<b>41,525.6</b>	<b>41,525.6</b>	-	<b>100.0</b>
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	41,525.6	41,525.6	-	100.0
<b>2112</b>	<b>Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр</b>	<b>9,548.3</b>	<b>9,548.3</b>	-	<b>100.0</b>
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	9,548.3	9,548.3	-	100.0
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>229,073.6</b>	<b>211,114.7</b>	<b>17,958.9</b>	<b>92.2</b>
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>61,079.3</b>	<b>47,126.9</b>	<b>13,952.4</b>	<b>77.2</b>
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	61,079.3	47,126.9	13,952.4	77.2
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b>167,994.4</b>	<b>163,987.9</b>	<b>4,006.5</b>	<b>97.6</b>
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	167,994.4	163,987.9	4,006.5	97.6
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>457,550.5</b>	<b>424,545.9</b>	<b>33,004.6</b>	<b>92.8</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>431,344.9</b>	<b>408,619.3</b>	<b>22,725.6</b>	<b>94.7</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	431,344.9	408,619.3	22,725.6	94.7
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>26,205.6</b>	<b>15,926.7</b>	<b>10,278.9</b>	<b>60.8</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	4,322.1	2,450.3	1,871.8	56.7
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,674.1	1,661.7	12.4	99.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,962.8	2,986.3	6,976.5	30.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,027.5	1,599.3	428.2	78.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,219.1	7,229.2	989.9	88.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>828,968.4</b>	<b>522,211.0</b>	<b>306,757.4</b>	<b>63.0</b>
220001	Барилга байгууламж	487,351.9	321,977.1	165,374.8	66.1
221001	Их засвар	32,395.8	13,150.6	19,245.2	40.6
222001	Тоног төхөөрөмж	22,348.7	14,625.6	7,723.1	65.4
223001	Бусад хөрөнгө	286,872.0	172,457.7	114,414.3	60.1
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>39,924.3</b>	<b>39,924.3</b>	-	<b>100.0</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	39,924.3	39,924.3	-	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,357,713.3</b>	<b>1,921,282.2</b>	<b>436,431.1</b>	<b>81.5</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>41,325.1</b>	<b>40,715.7</b>	<b>609.4</b>	<b>98.5</b>
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	41,325.1	40,715.7	609.4	98.5
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,928,283.6</b>	<b>1,864,480.1</b>	<b>63,803.5</b>	<b>96.7</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,928,283.6	1,864,480.1	63,803.5	96.7
